



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№83 /296/

2022.04.29

Цаг үе, үйл явдал

АНХНЫ ЭМЭГТЭЙ ГЕНЕРАЛТАЙ 78-Н ЖИЛИЙН ОЙН “МОНГОЛ ГЕНЕРАЛЫН ӨДӨР” БАХДАМ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ



Өдгөөгөөс 78 жилийн өмнө буюу 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн тогтоолоор цэргийн гарамгай 11 зүтгэлтэнд “Генерал” хэмээх цэргийн дээд цолыг анх удаа олгосноос хойш жил бүрийн энэ өдрийг алтан мөрдөстнүүдийн өдөр болгон тэмдэглэж ирсэн түүхтэй. Жил бүрийн энэ өдөр төрийн цэрэг болон хууль сахиулагч байгууллагаас алтан мөрдөстнүүддээ ээлжлэн хүлээн авч, хүндэтгэл үзүүлж ирсэн уламжлалтай бөгөөд энэ жил Төрийн тусгай хамгаалалтын газраас хариуцан ажиллаа.

2004 оноос хойш ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлдэг эл өдрөөр алтан мөрдөст генералуудаараа бахархах, тэдний гавьяа зүтгэл, дайчин уламжлалыг нь хойч үеийнхэнд өвлүүлэх, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх өндөр ач холбогдолтой юм. Өчигдөр зохион байгуулагдсан “Монгол генералын өдөр”-ын баярт Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэг хүчний ерөнхий командлагч оролцож болгон 2021, 2022 онд генерал цол хүртсэн болон цол ахисан генералуудын цолны үнэмлэхийг нь гардуулан өгөхийн зэрэгцээ алтан мөрдөст генералууд болон тэдний гэр бүлийнхэнд хандан “Монгол Улсын төлөө зүтгэж ирсэн генералууд Та бүхний ард Зэвсэгт хүчний бат бэх ар тал, ёс суртахууны үндэс суурь нь болсон гэр бүл, үр хүүхэд тань байдаг. Тиймээс энэ өдөр бол жагсаалын цэргээс төрийн генерал хүртэл нь амьдралынх нь үнэнч хань, амжилтынх нь өмөг түшиг болж, алдаа оноо бүрийнх нь ард сэтгэл догдлон байдаг ар гэрийнхэн Та бүхний ч баярын өдөр юм. Эх орноо хамгаалагч цэрэг эрсийн манлай болсон эрхэм алтан мөрдөст

Та бүхэндээ болон амьдралын тань өмөг түшиг болсон үнэнч хань, үр хүүхдүүдэд тань “Монгол генералын өдөр”-ийн баярын мэндийг дахин дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Та бүхнийг Монгол цэргийн Их хар сүлд өнө мөнхөд ивээж, Монгол цэргийн яруу алдар үеийн үед мандан бадрах болтугай” хэмээн мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Сонирхуулахад, Монгол Улсад генерал цол олгож эхэлснээс хойших 78 жилийн хугацаанд 207 цэргийн зүтгэлтэн энэ эрхэм цолыг хүртсэний дотор маршал нэг, армийн генерал нэг, хурандаа генерал найм, дэслэгч генерал 21, хошууч генерал 117, бригадын генерал 59 байна. Мөн энэ онд Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн баяраар Монгол Улсын анхны эмэгтэй генерал төрөн гарсан. Энэ бол Зэвсэгт хүчний хөгжлийн шинэ чиг хандлага, бүтэц бүрэлдэхүүнийг нь өөрчлөлтийн илэрхийлэл төдийгүй, улс орныхоо хөгжил дэвшил, батлан хамгаалах үйл хэрэгт эмэгтэйчүүдийнхээ гавьяа, зүтгэлийг төр засаг өндрөөр үнэлж буйн нотолгоо болсон юм.

Түүнчлэн генералуудын эгнээнээс БНМАУ-ын баатар цолтон зургаа, Хөдөлмөрийн баатар гурав, дайн, байлдаанд оролцсон 34, төрийн өндөр албан тушаал хашсан 15, сансрын нисгэгч нэг, Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн болон олон улсын байгууллагад ажилласан 10 гаруй генерал байгаа бөгөөд нийт генералын 30 гаруй хувь нь эрдмийн зэрэг, цолтон байдаг ажээ.



АВЛИГЫН ШАЛТГААН, ХОР ХӨНӨӨЛИЙН ТУХАЙ СУРГАЛТ ЯВУУЛЛАА

БХЯ нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон УИХ-ын 2016 оны тогтоолоор батлагдсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд БХЯ-ны хүсэлтээр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар

Н.Батчулуун, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн комиссар Б.Бат-Очир нар авлига, авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөлийн талаар БХЯ-ны бие бүрэлдэхүүнд сургалт явууллаа.

Сургалтаар авлигын шинж чанар, түүнтэй тэмцэж буй олон улсын туршлага, өөрийгөө болон бусдыг авлигын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зэрэг олон талын сэдвийг хөндөн ярилцлаа.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,272,920 /69.9%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,175,481 /66.9%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,039,267 31,9%
123,504 /3,8%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8461 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
10

ЭДГЭРСЭН
8330

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 512,181,416

Эдгэрсэн

Нийт: 465,885,071

Нас барсан

Нийт: 6,256,249

ИРГЭН ТА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛАА ХЭРХЭН ТӨЛӨХ БЭ?

- ✓ АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
- ✓ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ (Дунжигараа, Мишээл экспо, Драгон, Банкхошуу, Икерт 3,4 хороолол)
- ✓ БҮХ ТӨРЛИЙН ИНТЕРНЕТ БАНК
- ✓ ЭМДЕГ-ЫН ГАР УТАСНЫ EDAATGAL АППЛЕКЕЙШН
- ✓ И-БАРИЛТААР ТУС ТУС ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ.



Лавлах утас: 1800-1363

©Эрлийзүүлэлт /Үрьдчилан сэргийлэх газар

Э.Сорпил, Э.Эрдэнэ, Д.Доржиев, Д.Орвог, Д.Орвог

Цахим шууданд

АНГИЙН ХАМТ ОЛОН САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЛЭЭ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Хурандаа У.Буянжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн хамт олон сайн эмч болохын ерөөлийг зардалд сэтгэлийн хандиваа өргөлөө. Энхрий бяцхан охины өвчин нь хурдан илааршиж эх орондоо их зүйлийг бүтээх аялал болгохын ерөөлийг өргөж далайд дусал нэмэр болдгийн адилаар нэг сая нэг зуун тавин долоон мянган

төгрөгийг гардуулан өглөө. Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн хамт олон мөрдэс нэгт алба хаагчдаа "Сайн үйлсийн аян"-д нэгдэхийг уриалж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай. Ташрамд сэтгэлийн хандив илгээж байгаа Зэвсэгт хүчний дайчид нөхөд, Онцгой байдлын журмын нөхөд, түшээд босгох эрхэм найз нөхөд, ах дүү хамаатан садан, сайхан итгэлт иргэн та бүхэндээ маш их баярлалаа

хэмээн бяцхан охины аав, ээж уламжилсаар байна. Бяцхан охины эрүүл мэндээс шалтгаалан хагалгааг 5 дугаар сарын эхээр хийхээр төлөвлөсөн учир үлдсэн 80 хувийн эмчилгээний зардлаа богино хугацаанд бүрдүүлэх бодит шаардлага офицер, ахлагчийн гэр бүлд нь үүсээд байгаа юм. Иймд сайхан сэтгэлтэй хэн бүхнийг хандивын аянд нэгдэхийг уриалж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

Б.ДОЛГОРСҮРЭН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ДУГААР АНГИЙНХАН БЯЦХАН ОХИНЫ ЭМЧИЛГЭЭНД 33 САЯ ТӨГРӨГ ХАНДИВЛАЛАА

Сурвалжлагчаар ажилласан 10 гаруй жилийнхээ хугацаанд бараг хамгийн анх удаа байхдаа инээсээр, баярласаар, бахархсаар мэдээ бичиж байна. Журмын нөхөд нь офицерынхоо бяцхан охины амь нас, эрүүл мэндийн төлөө яаж хичээж, яаж нэгдэж, нэгдээд цугласан хандиваа гардуулахдаа яаж баярлаж байгааг нь харах завшаан өнөөдөр тохиов. Учир нь юу гэвээс Зэвсэгт хүчний 350 дугаар захирагчийн нэгдүгээр орлогч, дэд хурандаа Б.Ууганбаяр, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 22 дугаар ангийн дуудлага хүлээн авагч, ахлагч С.Ганзаяа нарын тархины үрэвсэл өвчнөөр шаналж байгаа бяцхан охины эмчилгээнд 33 сая төгрөг цуглуулснаа тус ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир өнөөдөр ёслол төгөлдөр гардуулан өгөв. Хурандаа Ж.Сүх-Очир "Бяцхан охин

У.Маргад бол бидний охин, манай ангийнхны гүнж. Ангийнхаа офицер, ахлагч, ажилтан албан хаагчийн хүүхдүүдийг өөрийн үр хүүхдүүд шиг хайрлаж явдаг юм. Ядрахад түшээд авах нөхөд, дэмжээд босгох хамт олон бол Зэвсэгт хүчний 350 дугаар ангийнхэн гэмээр байна. Хамт олны минь сэтгэл шингэсэн энэхүү хандив бяцхан охинд маш том нэмэр болно гэдэгт эргэлзэхгүй байна. Манай Ууганаа, Ганзаяа хоёрт туслаж байгаа мөрдэс нэгт нөхөдөө, сайхан сэтгэлт олон түмэндээ маш их баярлалаа" хэмээсээр хандиваа гардууллаа. Ийнхүү сайхан сэтгэлт иргэд, Зэвсэгт хүчин, Онцгой байдлын мөрдэстэй бүхэн бяцхан охины төлөө их, бага гэлтгүй сэтгэлийн хандиваа илгээсээр байна. Бяцхан охины эмчилгээний 450 сая төгрөгөөс 100 сая төгрөг нь одоогоор бүрдээд байна. Сэтгэлийн хандив

илгээж байгаа Зэвсэгт хүчний дайчид нөхөд, Онцгой байдлын журмын нөхөд, түшээд босгох эрхэм найз нөхөд, ах дүү хамаатан садан, сайхан итгэлт иргэн та бүхэндээ маш их баярлалаа хэмээн бяцхан охины аав, ээж уламжилсаар байна. Бяцхан охины эрүүл мэндээс шалтгаалан хагалгааг 5 дугаар сарын эхээр хийхээр төлөвлөсөн учир үлдсэн эмчилгээний зардлаа богино хугацаанд бүрдүүлэх бодит шаардлага офицер, ахлагчийн гэр бүлд нь үүсээд байгаа юм. Иймд сайхан сэтгэлтэй хэн бүхнийг хандивын аянд нэгдэхийг уриалж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

ХАНДИВЫН ДАНС
ХААН БАНК:
 5073035840
ГОЛОМТ БАНК:
 4305125348
Данс эзэмшигч: Ээж-Сэргэлэн Ганзаяа
Харилцах утас
С.Ганзаяа 88376062



АЛДАР СПОРТ ХОРООНЫ БАГ ТАМИРЧИД ДЭД БАЙР ЭЗЭЛЛЭЭ

Алдар спорт хороо
 Чөлөөт бөхийн 2022 оны "U-17" хүртэлх насны Улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 26-28-ны өдрүүдэд "Буянт-Ухаа" спорт цогцолборт болж дүнгээ гаргалаа. Монгол Улсын далбааг олимп, тив, дэлхийн тавцанд гаргасан алдарт тамирчдынхаа залгамж халааг бэлтгэх үр чадварыг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнийг өрнүүлэх, "U-17" ангиллын ДАШТ болон Азийн аварга шалгаруулах тэмцээнд улсаа төлөөлөн оролцох баг тамирчдыг сонгох зорилготой тус тэмцээнд хот, хөдөөгийн 33 байгууллагын 527 тамирчин өрсөлдлөө.

Уг тэмцээнд Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны гавьяат дасгалжуулагч Ц.Хосбаяр, гавьяат тамирчин Б.Одончимэг, гавьяат тамирчин Г.Мандахнаран дасгалжуулагчтай баг тамирчид оролцож, 1 алт,



2 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 95 оноогоор мөнгөн цомын эзэн боллоо. Тодруулбал, эмэгтэй 61 кг Э.Оюун-Эрдэнэ хүрэл, 65 кг Нархажид мөнгө, 49 кг Г.Соёлмаа алт, 57 кг Г.Арвинбаяр хүрэл, 73 кг Т.Уянга-Эрдэнэ мөнгөн медаль тус тус хүртсэн бол эрэгтэйчүүдийн төрөлд 55 кг М.Сумъяабазар хүрэл,

51 кг Б.Наран-Өлзий хүрэл медалийн эздээр шалгарав. Энэ удаагийн тэмцээний жин тус бүрийн аваргууд 6 дугаар сарын 19-26-нд Кыргызстаны Бишкект болох "U-17" Азийн аварга шалгаруулах тэмцээн, 7 дугаар сарын 25-31-нд Италийн нийслэл Ромд болох ДАШТ-д оролцох эрхтэй болж байгаа юм.

ЖУДО БӨХИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН



- А.Адьяасүрэн /алт/ +78 кг-ийн жинд
- Б.Номинзул /мөнгө/ Эрэгтэй - 60 кг-ийн жинд
- Э.Ариунболд /хүрэл/ -66 кг-ийн жинд
- Б.Эрхэмбаяр /алт/ -100 кг-ийн жинд
- О.Хангал /мөнгө/ -100 кг-ийн жинд

Дундговь аймаг Мандалговь хотноо жудо бөхийн эрэгтэйчүүдийн 45 дахь удаагийн, эмэгтэйчүүдийн 30 дахь удаагийн 2022 оны насанд хүрэгчдийн Монгол улсын аварга шалгаруулах тэмцээн дөрөвдүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны ОУХМ хошууч П.Нямлхагва, ОУХМ хошууч Д.Батсайхан дасгалжуулагчтай баг тамирчид оролцож, 4 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж нийт багийн дүнгээр нэгдүгээр байрт мөн эмэгтэй баг тамирчид маань багийн дүнгээр нэгдүгээр байрт тус тус орлоо. Үүнд :
 Эмэгтэй
 -48 кг-ийн жинд Г.Наранцэцэг /мөнгө/
 -52 кг-ийн жинд А.Гал-



- Од /мөнгө/ -63 кг-ийн жинд
- Б.Ганхайч /алт/ -78 кг-ийн жинд
- Б.Эрдэнэт-Од /алт/ +78 кг-ийн жинд
- Г.Алтанбагана /хүрэл/ +100 кг-ийн жинд
- С.Бат-Орших /мөнгө/ +100 кг-ийн жинд
- Х.Цогтгэрэл /хүрэл / медаль тус тус хүртлээ.

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН АМЖИЛТЫН БУУХИА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монгол Улсын Ардын багш, Монгол Улсын Гавьяат жүжигчин, Профессор, нэрт бүжиг дэглээч, судлаач, багш Г.Долгорсүрэнгийн нэрэмжит "Гоцлол бүжигчдийн улсын анхдугаар уралдаан"-нд авьяас билэг, уран чадвараараа нийт 100 гаруй бүжигчид өрсөлдөн шилдгүүдээ тодрууллаа. Тус уралдаанд ЦДБЭЧ-ын бүжигчид амжилттай оролцож гоцлол бүжигчин МУСТА ахлах ахлагч Х.Юүлэхорол "Гранпри" шагнал, бүжигчин ахлагч А.Энхжаргал "Тусгай байр"-ын шагнал, гоцлол бүжигчин ахлагч Б.Бат-Өлзий "Монголын урлагийн ажилтны холбооны нэрэмжит шагнал"-аар шагнагдлаа.